

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

БАТЛАВ

Ж.МӨНХЧУЛУУН

2017 оны 09 сарын 28

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ
“БАГА ОЛИМП-2017” УДИРДАМЖ**

ОЛИМПЫН УРИА: НЭГ ЗОРИЛГО-НЭГ БАГ

Нэг. Зорилго

Олимпын спортын төрлүүдийг орон нутагт хөгжүүлж, иргэдийн эрүүл мэндийг дэмжин хамгаалах, спортоор дамжуулан бүх нийтээрээ нэг ирээдүйн хөгжлийн төлөө нэг зорилго, тэмүүлэл дор эвлэлдэн нэгдэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Дундговь аймгийн 15 сум оролцоно.

Гурав. Хугацаа

“Бага олимп-2017” нь 2017 оны 10 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Мандалговь хотод зохион байгуулна.

Техникийн зөвөлгөөн 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 16 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 2 давхрын хурлын зааланд болно.

Тамирчдын мэдүүлгийг хүргүүлсэн загвар хүснэгтийн дагуу гаргаж, сум, багийн Засаг даргын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан, 2017 оны 10 дугаар сарын 12-ны дотор Биеийн тамир, спортын газар ирүүлнэ.

Дөрөв. “Бага олимп-2017” явагдах байршил, хуваарь

№	Төрөл	Хугацаа	Байршил
1	Сагсан бөмбөг	10 сарын 20-21	БТСГ-ын спорт заал, ЭДЦС-ийн спорт заал
2	Волейбол	10 сарын 20-22	МСҮТ, Мандал сургууль, Цагдаагийн газар, МГСС-ийн спорт заал
3	Ширээний теннис	10 сарын 20-21	ЭДЦС-ийн спорт заал
4	Шатар	10 сарын 20-21	ГБХЗХГ-ын урлаг заал 1
5	Зуун буудалт даам	10 сарын 20-21	ГБХЗХГ-ын урлаг заал 2
6	Үндэсний бөх	10 сарын 22	БТСГ-ын спорт заал
7	Дартс	10 сарын 20	МГСС-ийн урлаг заал

Тав. "Бага олимп-2017" төрөл, хариуцсан шүүгчид

№	Төрөл	Шүүгч	Албан тушаал
Ерөнхий шүүгч - С.Цолмон /БТСГ-ын мэргэжилтэн/			
1	Сагсан бөмбөг	О.Буянтогтох	БТСГ-ын дасгалжуулагч
2	Волейбол	Д.Болор-Эрдэнэ	БТСГ-ын дасгалжуулагч
3	Шатар	А.Ууганбаяр	"Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын дарга
4	Зуун буудалт даам	Ц.Ганзориг	ГБХЗХГ-ын дарга
5	Үндэсний бөх	Н.Батсайхан	ГИЦС-ийн багш
6	Дартс	Н.Шижирболд	УБХ-ийн ажилтан
7	Ширээний теннис	Г.Эрдэнэбилэг	Сайнцагаан сумын 3 дугаар сургуулийн сургалтын менежер

Зургаа. Зохион байгуулалт

- "Бага олимп-2017"-г аймгийн Засаг дарга болон ивээн тэтгэгч байгууллагууд хамтран санхүүжүүлж, томилогдсон комисс удирдан зохион байгуулна.
- Сум, багууд батлагдсан хуваарийн дагуу олимпын бүх төрөлд заавал оролцоно.
- Сагсан бөмбөг, волейболын тэмцээнийг Монголын сагсан бөмбөгийн холбоо, Монголын волейболын холбооны дүрмийн дагуу шүүн явуулна.
- Сайнцагаан сумын 1, 3, 7-р баг, 4, 5, 8-р баг, 2, 6, 9-р багууд тус тус нийлж нэг баг болж оролцоно.
- Сумдын Засаг дарга нар багаа ахалж оролцоно.
- "Бага олимп-2017"-д спортын 7 төрөлд оролцох багийн бүрэлдэхүүн, насны ангилал:

№	Төрөл	Баг	Насны ангилал		Багийн бүрэлдэхүүн
1	Сагсан бөмбөг	Эрэгтэй, Эмэгтэй	18 ба түүнээс дээш нас		8 тамирчин
2	Волейбол	Эрэгтэй	Залуучууд	18-39 нас	8 тамирчин
			Ахмад	40-49 нас	4 тамирчин
				50 ба түүнээс дээш	4 тамирчин
			Эмэгтэй	Залуучууд	18-35 нас
		Ахмад		36-41 нас	2 тамирчин
				42-45 нас	2 тамирчин
				46-49 нас	2 тамирчин
			50 ба түүнээс дээш	2 тамирчин	

3	Ширээний теннис	Эрэгтэй, Эмэгтэй ганцаарчилсан, холимог хос	18-39 нас	Эрэгтэй 2 тамирчин
			40 ба түүнээс дээш нас	Эмэгтэй 2 тамирчин
4	Шатар	Эрэгтэй, Эмэгтэй	18 ба түүнээс дээш нас	Эрэгтэй 1 тамирчин, Эмэгтэй 1 тамирчин
5	Зуун буудалт даам	Эрэгтэй, Эмэгтэй	18 ба түүнээс дээш нас	Эрэгтэй 1 тамирчин, Эмэгтэй 1 тамирчин
6	Үндэсний бөх	Ганцаарчилсан	18 ба түүнээс дээш нас	5 бөх
7	Дартс	Эрэгтэй, Эмэгтэй	18 ба түүнээс дээш нас	Эрэгтэй 2 тамирчин, Эмэгтэй 2 тамирчин

Долоо. Тавигдах шаардлага, тэмцээний журам

1. "Бага олимп-2017"-д 18 ба түүнээс дээш насны тамирчид оролцох бөгөөд тамирчдын насны хязгаарыг төрсөн оноор нь тооцно.
2. Тэмцээний зохион байгуулалт, явцтай холбоотой аливаа санал, гомдлыг ерөнхий шүүгчид бичгээр өгөх ба уг асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэн хариу мэдэгдэнэ.
3. Зөвхөн нэг багийн эрх ашигт нийцсэн санал хүсэлтийг хүлээж авахгүй.
4. Техникийн зөвөлгөөнд багийн дасгалжуулагч ба ахлагч багийн гишүүдтэйгээ оролцож, хуваарийн дагуу мандатын комиссоор орно.
5. Багийн дасгалжуулагч буюу багийн төлөөлөгч нь шаардлагатай тохиолдолд тамирчдын мандатыг бэлэн байлгана.
6. Тамирчдын иргэний үнэмлэх болон хурууны хээг үндэслэн Дундговь аймгийн үндсэн хаягтай эсэхийг шалган тогтоож, Улсын бүртгэлийн хэлтсээс гаргасан лавлагааг үндэслэн мандат олгоно.
7. Дундговь аймгийн үндсэн хаяг дээр байхгүй иргэнийг "Бага олимп-2017"-д оролцуулахгүй бөгөөд 1 тамирчин 2-оос илүү төрөлд оролцож болохгүй.
8. Тамирчид мандатаар орохдоо 2 хувь цээж зурагтай ирнэ.
9. Багийн тамирчид медаль, тэмдгээ зүүж, сум, багийнхаа туг далбааг барин, "Бага олимп-2017" нээлтийн болон хаалтын ёслолын арга хэмжээнд бүрэн бүрэлдэхүүнээрээ заавал оролцоно.
10. Тамирчид нь сахилга дэг журмыг бүрэн хангаж, тэмцээний зохион байгуулалтын шаардлагыг биелүүлнэ.
11. Сагсан бөмбөг, волейболын тамирчид нь тоглолтын 2 ээлжийн хувцсаар жигдэрсэн байх бөгөөд ар, энгэрийн хувийн дугаар тавьсан байна.
12. Ахмадын волейболын тэмцээнд 50 ба түүнээс дээш насны тоглогч талбай дээр заавал тоглоно.
13. Ширээний теннисний тамирчид тоглолтын зориулалтын өмсгөл, өөрсдийн цохиуртай байна.
14. Үндэсний бөхийн барилдаанд оролцох бөхчүүд өөрийн зодог, шуудаг, монгол гуталтай байна.
15. Шатар, даамны тэмцээнд оролцох тамирчид өөрсдийн шатар, даамтай байна.

Найм. Дүгнэх журам, шагнал урамшуулал

Төрөл, ангилал тус бүрт эхний 3 байр эзэлсэн баг, тамирчдыг медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Сагсан бөмбөг, волейболын төрөлд тус бүр шилдэг эрэгтэй, эмэгтэй 1 тамирчныг шалгаруулж, дурсгалын цомоор шагнана.

Үндэсний бөхийг багийн болон хувийн амжилтаар нь байр эзлүүлж, дүнг гаргана.

Спортын 7 төрлийн нийлбэр дүнг их онооны системээр дүгнэн, 1, 2, 3-р байр эзэлсэн багийг цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнана.

Тэмцээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 99598380, 89862538, 99704823 дугаарын утсаар болон Биеийн тамир, спортын газраас авна уу.

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС